# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр Дугаар А/565 Номгон

"Богд сумын эмнэлгийн барилгын дээврийн засварын" ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /а/ дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Богд сумын эмнэлгийн барилгын дээврийн засварын" 50,000,000 /Тавин сая/ төгрөгийн ажлыг тус сумын Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлж гүйцэтгүүлсүгэй.

2.Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Богд сумын Засаг дарга (Д.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх 50,000,000 (Тавин сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4."Богд сумын эмнэлгийн барилгын дээврийн засварын" ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

601710311